



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 4 сарын 10 -ны өдөр

Дугаар А/АН

Эрдэнэт

Тусгаарлах эмнэлгүүдийн тусламж  
үйлчилгээний шуурхай байдлыг хангах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн В.1.1, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2021 оны Коронавируст халдварын үед эмнэлзүйн зөвлөх баг ажиллуулах тухай А/317, "Оношилгоо эмчилгээний заавар батлах тухай А/318, "Түр заавар батлах тухай" А/416, Шинэ коронавируст халдвар / Ковид-19/-ын оношилгоо, эмчилгээний түр зааврыг шинэчлэн батлах тухай А/456 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгаарлах эмнэлгүүдийн коронавируст халдвар /Ковид-19/-ын тохиолдлыг хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлэх орны тоо, чиглэл, орон ажиллах эрүүл мэндийн байгууллагын хуваарийг нэгдүгээр, тусгаарлах эмнэлэгт хэвтүүлэх журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тусгаарлах эмнэлэгт дэлгэсэн ор, хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын бэлэн байдлыг хангаж хуваарийн дагуу орон ажиллах багийг тушаалаар томилон, эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв /Ц.Наран-Эрдэнэ/, Ачит эмнэлэг /Б.Цэнджав/, Бадархундага эмнэлэг/Б.Гүнчинсүрэн/, Талын булаг эмнэлэг/Р.Жаргал/, Баян-Өндөрмед нэгдсэн эмнэлэг /Л.Байгаль/, Медипас төв эмнэлэг /Я.Энхчулуун/ Эрдэнэт сувилалын цогцолбор /Ж.Ганчимэг/ нарт даалгасугай.
3. Коронавируст халдвартай жирэмсэн эх, төрсний дараах 42 хоног доторхи төрсөн ээж болон хүндрэх эрсдэлтэй, хавсарсан суурь эмгэгтэй, амьсгалын дутагдалтай, хүнд, нэн хүнд тохиолдол бүрт Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/317 дугаар тушаалаар томилогдсон зөвлөх багаас мэргэжил аргазүйн зөвлөмж, дэмжлэг авч ажиллахыг Ц.Наранэрдэнэ /Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал /-д даалгасугай.
4. Ковидын хүнд, нэн хүнд тохиолдлыг эрт илрүүлэн хугацаа алдалгүй 2 дахь шатлалын эмнэлэгт шилжүүлж тусламж үйлчилгээний хожимдолгүй, хүлээгдэл чирэгдэлгүй,

гэрийн нас баралт гаргахгүй ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Тусгаарлах эмнэлгүүд, Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

5. Коронавируст халдвар /Ковид-19/-тай тохиолдлыг эмнэлгийн болон эмнэлгийн бус орчинд хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлэхэд мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлзүйн зөвлөх баг, Б.Уртнасан /ЭТҮХМ/-д, Б.Одонтунгалаг /БОЭТ-ийн ЭЗОЗахирал/, тусгаарлах эмнэлгүүдийн халдварын сэргийлэлтэнд хяналт тавьж ажиллахыг Б.Билгүүнээ /Халдвар судлаач/ нарт үүрэг болгосугай
6. Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг тусгаарлан эмчлэхтэй холбоотой санхүүжилт, зарцуулалтыг тушаал, журмын дагуу хянаж ажиллахыг Х.Чулуун-Эрдэнэ /СББМНБ-ын ажилтан/ -д даалгасугай.
7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Г.Энхжаргал /ХШҮХМ /-д даалгасугай

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Тусгаарлах эмнэлгүүдийн коронавируст халдвар /Ковид-19/-ын тохиолдлыг хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлэх орны тоо, чиглэл, орон ажиллах эрүүл мэндийн байгууллагын хуваарь

№	Тусгаарлах эмнэлгүүд	Нийт орны тоо	Эмнэлэгт хэвтүүлэх шалгуур, эрсдэлт хүчин зүйл, эмнэлзүйн хэлбэр	Тусгаарлах эмнэлэг ажиллаж эхэлсэн огноо	Орон ажиллах ЭМБайгууллага
1	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Халдвартын тасаг 25 ор	<ul style="list-style-type: none"> <li>- 55-с дээш насны ахмад</li> <li>- Жирэмсэн эх</li> <li>- Төрсний дараахь 42 хоног доторх эхчүүд</li> <li>- Артерийн даралт ихсэлт</li> <li>- Чихрийн шижин</li> <li>- Зүрх судасны хүнд өвчнүүд</li> <li>- Таргалалт</li> <li>- Уушигны архаг өвчин</li> <li>- Хаадартай</li> <li>- Дархлаа дарангуйлагдсан байдал</li> <li>- IV, V бүлгийн иргэд</li> <li>- ХБИргэн</li> <li>- Ковидын хүнд, нэн хүнд хэлбэр</li> </ul>	2021 оны 03 сарын 24	БОЭТ-ийн бэлтгэгдсэн багууд
		Хүүхдийн тасаг 100 ор		2021 оны 04 сарын 23	БОЭТ-ийн бэлтгэгдсэн багууд
		Эрдэнэт сувилал цогцолбор 100 ор		2021 оны 06 сарын 04	ЭСЦ-ын бэлтгэгдсэн багууд
2	Ачит эмнэлэг	50 ор	Хөнгөн хэлбэр	2021 оны 06 сарын 10	Ачит эмнэлгийн 2-р баг
3	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв	Бадархундага эмнэлэг 50 ор Талын булаг эмнэлэг 50 ор	Хөнгөн хэлбэр	2021.06.21	-Ачит эмнэлэг -Баян-Өндөр мед эмнэлэг -Медипас төв эмнэлэг
4	Баян-Өндөрмед нэгдсэн эмнэлэг	60 ор	Хөнгөн, хүндэвтэр	2021 оны 07 сарын 19	БаянӨндөр нэгдсэн эмнэлгийн 2-р баг
5	Медипас төв эмнэлэг	40 ор	Хөнгөн, хүндэвтэр	2021 оны 07 сарын 19	Медипас эмнэлгийн 2-р баг
6	Нийт орны тоо	475			



### ТУСГААРЛАХ ЭМНЭЛЭГТ ХЭВТҮҮЛЭХ ЖУРАМ

1. Сум, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар нь коронавируст халдварт өртсөн иргэдийн мэдээллийг Google sheet программаас авч батлагдсан тохиолдлын гэрээр очиж үзэн эрэмбэлэн ангилж тус тушаалын нэгдүгээр хавсралтад заасан эмнэлэгт хэвтүүлэх шалгуур, эрсдэлт хүчин зүйл, эмнэлзүйн хэлбэрийг үндэслэн БОЭТ, тусгаарлах эмнэлгүүдтэй холбогдон эмнэлэгт хэвтүүлнэ.
2. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд хэвтүүлэх шаардлагатай бол Б.Одонтунгалаг /ЭЭОЗ/ утас 99057151, С.Энхмаа /ЭЧХАД/ утас 99270212 тус тус холбогдож хэвтүүлнэ.
3. Тусгаарлах эмнэлгүүдэд хэвтүүлэх шаардлагатай бол /, Ачит эмнэлэг /Б.Цэнджав/ 99352598, Бадархундага эмнэлэг/Б.Гүнчинсүрэн/99352335, Талын булаг эмнэлэг/Р.Жаргал/ 99093823, Баян-Өндөрмөд нэгдсэн эмнэлэг /Л.Байгаль 99359122 /, Медипас төв эмнэлэг /н.Туул/ 99116518 тус тус холбогдож хэвтүүлнэ.
4. Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь нийт ковидын орны 30 хүртлэх хувийг эрчимт эмчилгээний ор байхаар төлөвлөн зохион байгуулсан байна.
5. Тусгаарлах эмнэлгүүд нь явуулын амбулатороос илгээсэн үйлчлүүлэгчийг хүлээгдэл, чирэгдэлгүйгээр хүлээн авч хэвтүүлэн эмчилнэ.
6. Тусгаарлах эмнэлгүүд нь ковидын хүнд, нэн хүнд тохиолдлыг эрт илрүүлэн хугацаа алдалгүй дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний хожимдол үүсгэхгүй байхад онцгой анхаарч ажиллах
7. Сум, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар нь иргэнийг эмнэлэгт хэвтсэн эсэхэд эргэн хяналт тавина.
8. БОЭТ болон тусгаарлах эмнэлгүүд нь орны мэдээллийг өдөр бүр эрүүл мэндийн газарт ирүүлж ажиллах ба эмнэлэг бүр өдөрт 1-2 орны нөөцийг үлдээж яаралтай журмаар хэвтүүлэх иргэнийг хүлээж авах бэлтгэлийг хангаж ажиллана.
9. БОЭТ болон тусгаарлах эмнэлгүүд нь орны нөөц, ашиглалтад тухай бүр дүгнэлт судалгаатай ажиллаж нэмэлтээр ор дэлгэх хэрэгцээ шаардлага үүсч буй талаарх санал дүгнэлтийг ЭМГ-т урьдчилан ирүүлж ажиллах
10. Тусгаарлах эмнэлгүүд нь орлон ажиллах хүний нөөцийн хуваарилалтыг сайтар хийж хүний нөөцийн хомсдол, дутагдалд орох, тусгаарлах эмнэлгийн үйл ажиллагаа тасалдахаас сэргийлэх